



“МОН-ГЕО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 4-р сарын 29 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

“Монгео” ХК-ийн дүрмийн 6.7 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хуралдсан ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн санал нэгтэй зөвшөөрснийг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ :

1. Компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайланг зөвшөөрсүгэй .
2. Аудиторын дүгнэлтийг хүлээн зөвшөөрч аудитын өгсөн зөвлөмжид өгүүлсэн ажлыг хийж хэрэгжүүлэхийг нягтлан бодогчид үүрэг болгосугай .
3. Тус компанийн үйл ажиллагааны чиглэлээр зарлагдсан сонгон шалгаруулалтад зохих төсөв , тооцоо, судалгааг гаргаж идэвхтэй оролцсугай.
4. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх санхүүгийн тогтвортой байдлыг хангах ,ажлын байр нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор их хэмжээний зээл авах , гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрсүгэй.
5. ХУД-ийн 12-р хорооны нутагт байрлах компанийн эзэмшлийн 8,08 га газарт үйлдвэрлэлийн зорилгоор ашиглах төсөл төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,түүнчлэн тус газрыг түрээслүүлэх байдлаар үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх удирдлагад даалгасугай.
6. Өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт,мөнгөний ханшийн уналт, инфляцийн тогтворгүй байдалтай уялдуулан “Мон-Гео” ХК-ийн дүрмийн 8.5.1 дэх заалтыг өнөө үетэй зохицуулах замаар өөрчлөн найруулж, шинэчлэн баталсугай,
7. Компанийн санхүүгийн байдлыг тогтвортой , үр дүнтэй , үр өгөөжтэй болгохоор 2026-2030 онуудад шат дараатай хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөө, төслийг боловсруулах ажлыг хариуцан ажиллахыг ТУЗ-ийн гишүүд - /Ц.Алтансүх,М.Адилбиш /-нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ийн дарга/Н.Соёмбо /





“МОН-ГЕО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 4 -р сарын 29 өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

ТООЛЛОГЫН КОМИССЫН ШИЙДВЭР

Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хуралдсан ээлжит хурлын саналын хуудасны тоог үндэслэн хэлэлцэх асуудал бүрийг нийт саналын тоогоор батлав.



Тооллогын комиссын дарга: *Алтансүх* / Ч.Алтансүх /

Гишүүн: *Даваажаргал* / Г.Даваажаргал /

Гишүүн: *Түмэнжаргал* / Б.Түмэнжаргал /